



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 8/04

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймгийн Хархорин сум аялал жуулчлалын гудамжны ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай


Үнэлгээний хорооны дарга: Н.Ганболд -Аймгийн Засаг даргын дэргэдэх  
Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга Б.Пүрэвсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын бараа, зөвлөх үйлчилгээ худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Б.Мөнхбат -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Т.Нарангарав -Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Б.Одсүрэн -Мерси кор ОУБ-ын Өвөрхангай аймаг дахь салбарын зохицуулагч (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.



Ц.ГАНБОЛД

012100033

D: My Doc. Tushaal. ZDTG